



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/237

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6, 25.7, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн №17 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Коронавирусын халдвар /КОВИД-19/-т цар тахлын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах, яаралтай тусламж үзүүлэхэд нэн шаардлагатай багаж, тоног төхөөрөмж хавсралтаар баталсугай.

2. Дээрх зардалд шаардагдах 9300000 /есөн сая гурван зуун мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт дансны хандивын мөнгөнөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Г.Хэрлэнчулуун/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

04 Аймгийн Засаг даргын 2020 оны  
дугаар сарын 30 өдрийн А/237  
дугаар захирамжийн хавсралт

ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТ

№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо ширхэг	Нэгж үнэ төгрөг	Нийт үнэ төгрөг
1	Монитор	1	2,850,000	2,850,000
2	Дефибриллятор автомат	1	3,100,000	3,100,000
3	Яаралтай тусламжийн тэргэнцэр	1	1,850,000	1,850,000
4	Хүчилтөрөгч өтгөрүүлэгч	1	1,500,000	1,500,000
Нийт үнэ				<b>9.300.000</b>